



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/578

Есөнбулаг

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчит байгууллагын нэг автотээврийн хэрэгслийг 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр үнэ бууруулж нээлттэй дахин дуудлагын худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Өмчийн төлөөлөгч: Ж.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Хөтлөгч: Б.Золзаяа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Ч.Лхагвадулам (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2. Нээлттэй дуудлагын худалдааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг комисс (Ж.Билэгсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

